

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН  
ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН БУСАД ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН  
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2020 оны 12 дугаар  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгийн үнэлгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийлээ.

Төсөл санаачлагч нь үнэлгээний үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлох, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, үнэлгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, энэ чиглэлээрх төрийн болон мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага, үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээд, үйлчлүүлэгч, гуравдагч этгээдийн эрх, үүрэг, үйл ажиллагаатай холбогдсон харилцаа болон үнэлгээний тайлангийн чанар, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах хэрэгцээ, шаардлагын дагуу хуулийн төслийг шинэчлэн боловсруулжээ.

Байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотойгоор ФАТФ-аас өгсөн зөвлөмжид хөрөнгийн үнэлгээний тухай хуульд тогтоомжид өөрчлөлт оруулах чиглэл өгсөн, төрийн өмчийн компаниудын газар, машин тэрэг гэх мэт өмчийг үнэлэх хэрэгтэй, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг хөрөнгөө үнэлүүлэгчийн эрх ашиг болон өмчийн эрхийг хамгаалах, хувь хүний хөрөнгийг шударгаар үнэлэх, хамгаалах тал дээр анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан уг хуулийн төсөл нь хөрөнгийн эргэлт, хөрөнгийн үнэлгээний зүйлийн зах зээлийг хамгаалсан, дэмжсэн төсөл болсон бөгөөд хөрөнгийн үнэлгээний харилцаанд оролцогч үйлчлүүлэгч, үнэлгээчин, хэрэглэгч талуудын эрх ашгийг тэнцүү хамгаалсан хууль байх ёстой, энэ чигээрээ батлагдвал эдийн засгийн олон салбарын эрх ашиг хөндөгдөх тул ажлын хэсэг байгуулан ажиллах хэрэгтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дээрх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөрөнгийн үнэлгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн

тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Ж.ГАНБААТАР**